

Санхүүгийн мэдээллийн алба

ТИПОЛОГИЙН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭНЭЭС ЗАЙЛСХИЙХ
БОЛОН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭГ ТОЙРОН ГАРАХ НЬ

ШИНЭЧИЛСЭН ХУВИЛБАР 2.0

2026

АГУУЛГА

I. ЗОРИЛГО	2
II. ХОРИГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ.....	3
2.1 Хориг арга хэмжээний ангилал	5
2.2 Хориг арга хэмжээний хэрэгжилт	7
2.3 Хориг арга хэмжээний ач холбогдол, үр дагавар	8
2.4 Хоёрдогч хориг арга хэмжээ.....	9
III. САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ ОЛОН УЛСАД.....	10
3.1 Хориг арга хэмжээг тойрон гарахад гуравдагч улс, зуучлагч болон худалдааны өөр маршрут ашиглах	10
3.2 Хориг арга хэмжээнээс зайлсхийх, тойрон гарах зорилгоор виртуал хөрөнгийг ашиглах	11
IV. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	13
V. ТИПОЛОГИ.....	15
5.1 Санхүүгийн хориг арга хэмжээнээс зайлсхийх болон хориг арга хэмжээг тойрон гарах олон улсын типологи.....	15
VI. ШИНЖ ТЭМДЭГ.....	19
6.1 Бараа бүтээгдэхүүний импорт болон экспорттой холбоотой шинж тэмдэг	19
6.2 Харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой шинж тэмдэг	20
6.3 Санхүүгийн системтэй холбоотой шинж тэмдэг	21
VII. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ	24
АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖ	26

I. ЗОРИЛГО

Дэлхийн улс орнууд болон олон улсын засгийн газар хоорондын байгууллагууд, тухайлбал, НҮБ-ийн Аюулгүйн зөвлөл, Европын Холбоо зэрэг нь олон улсын энх тайван, аюулгүй байдалд заналхийлэх хүчин зүйлсийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор олон талт арга хэрэгсэл, механизмыг хэрэгжүүлэн ажилладаг.

Эдгээрийн нэг хориг арга хэмжээний бодлого, зохицуулалтыг сүүлийн жилүүдэд улс орнууд, олон улсын засгийн газар хоорондын байгууллагууд нь гадаад бодлогын хэрэгсэл болгон өргөнөөр ашиглах болсон байна. Үүнийг тоон мэдээллээр харвал хориг арга хэмжээ авдаг томоохон улс орнууд болон олон улсын байгууллагаас авсан хориг арга хэмжээний тоо 2021-2024 оны хооронд тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Жишээлбэл, Европын Холбооноос гаргадаг хориг арга хэмжээний тоо нь 2020 он хүртэлх хугацаанд хамгийн ихдээ 298 (243 хувь хүн, 55 хуулийн этгээд)-д хүрч байсан. Гэтэл 2022 онд хориг арга хэмжээний тоо 1510 (1349 хувь хүн, 161 хуулийн этгээд), 2023 онд 767 (489 хувь хүн, 278 хуулийн этгээд) болж өссөн байна.

Монгол Улс нь олон улсад авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээнүүдээс терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтыг дагаж мөрдөх үүрэг хүлээдэг. Бусад олон улсын засгийн газар хоорондын байгууллага болон нэг талт хориг арга хэмжээг заавал дагаж мөрдөх үүрэг хүлээдэггүй болно. Гэвч нэг талт болон олон талт хориг арга хэмжээнд орсон улс орнууд нь гуравдагч улс орнуудыг ашиглан хориг арга хэмжээнээс зайлсхийх эрсдэл нэмэгдэж байна.

Эдгээр олон улсад гарч буй хориг арга хэмжээтэй холбогдуулан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тогтолцооны хүрээнд дагаж мөрдөх хориг арга хэмжээ, урьдчилан сэргийлэх арга зам болон хориг арга хэмжээнээс зайлсхийх түгээмэл чиг хандлагыг тусгасан типологийн тайлан боловсруулах шаардлага үүсээд байна. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас санхүүгийн хориг арга хэмжээнээс зайлсхийх, хориг арга хэмжээг тойрон гарахтай холбоотой типологийн тайланг боловсруулав.

Уг типологийн тайланг дараах зорилгын хүрээнд боловсруулав. Үүнд:

1. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хориг арга хэмжээтэй холбоотой ойлголтыг нэмэгдүүлэх, дагаж мөрдөх хориг арга хэмжээний жагсаалтыг таниулах,
2. Хориг арга хэмжээнээс зайлсхийх, хориг арга хэмжээг тойрон гарах зорилготой үйлдэл, гүйлгээг таньж мэдэх, илрүүлэх, хэрхэн зогсоох арга хэмжээ авах талаар чадавхыг нэмэгдүүлэх,
3. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн “хориг арга хэмжээг тойрон гарах үйл ажиллагаанд санаатай болон санамсаргүй байдлаар оролцож болзошгүй” харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээг таньж илрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг болох.

II. ХОРИГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Аливаа улсын Засгийн газрын үндэсний ашиг сонирхолд заналхийлсэн, эсхүл олон улсын хэм хэмжээ, эрх зүйн актыг зөрчсөн улс орон, хувь хүн, хуулийн этгээдийн санхүүгийн эрх чөлөө, эдийн засаг, бизнесийн үйл ажиллагааг хязгаарлах зорилгоор бусад улс орон болон олон улсын байгууллагын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээг **хориг арга хэмжээ** гэж ойлгож болно.

Хориг арга хэмжээг анх МЭӨ 432 онд Афинчууд “Мегарын тогтоол”-д Мегарачуудыг Афины боомтуудад нэвтрэхийг хориглон, Мегара хоттой хийх худалдааг хязгаарласнаар ашиглаж байсан¹, үүнээс хойш Дэлхийн нэгдүгээр дайны дараа Үндэстний лиг хориг арга хэмжээг хамтын аюулгүй байдал гэх зарчмын дор анх удаа олон талт, эрх зүйн зохицуулалттай хэрэгсэл болгон баталжээ. Ингээд 1945 онд Нэгдсэн үндэстний байгууллага байгуулагдаж, дүрмийн 39, 41 дүгээр зүйлүүдэд Аюулгүйн зөвлөлд хориг арга хэмжээ авах бүрэн эрхийг тусгасан байна. Ингээд 1990-ээд оноос улс орныг чиглэсэн хориг арга хэмжээ зорилтот бүлэгт бус хоригт орсон улсын иргэдэд сөргөөр нөлөөлж буй тухай шүүмжлэлтэй ихээхэн тулгарснаар орчин үеийн санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ үүссэн байдаг. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл нь 1966 оноос хойш 31 хориг арга хэмжээ тогтоосон бөгөөд өнөөдрийн байдлаар 15 нь хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хориг арга хэмжээ нь улс орон хоорондын зөрчилдөөнийг хурцатгахаас урьдчилан сэргийлэх, зохицуулах, терроризмтой тэмцэх, кибер аюулгүй байдлыг бэхжүүлэх, хүний эрх зөрчигчдийг шийтгэх болон цөмийн зэвсэг дэлгэрүүлэхийг хязгаарлах зэрэг зорилго бүхий гадаад бодлогын нэг хэрэгсэл болдог. Хориг арга хэмжээг дараах чиг үүргийн хүрээнд ашигладаг. Үүнд:

- **Дохио өгөх:** Улс орон, бүс нутгийн байгууллага хориг арга хэмжээ ногдуулах замаар аливаа улсын бодлогод сөрөг байр суурьтай байгаагаа илэрхийлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг нээлттэй байдлаар үлдээдэг. Үүнийг нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын хэм хэмжээг зөрчсөн улс орнуудад ихэвчлэн ашигладаг.
- **Албадах:** Улс орон, этгээдэд эдийн засгийн зардал, дарамт учруулах замаар тухайн улсад баримталж буй бодлогоо өөрчлөхийг шаардах.
- **Чадавхийг хязгаарлах (саармагжуулах):** Зорилтот этгээдийг тодорхой зорилгоо (жишээ нь цөмийн зэвсэг хөгжүүлэх, терроризм санхүүжүүлэх) хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, технологи, санхүүжилтэд хүрэх боломжоос нь бодитоор таслах зорилготой.
- **Хариуцлага тооцох (шийтгэх):** Хориг арга хэмжээ тавьж буй улс орон, бүс нутгийн байгууллага нь өмнө нь гаргасан зөрчлийн (жишээ нь хүний эрх зөрчих) төлөө хариуцлага тооцох зорилгоор шийтгэх шинжтэй хориг арга хэмжээг

¹ Morgan, T. C., Syropoulos, C., & Yotov, Y. V. (n.d.). Economic Sanctions: Evolution, Consequences, and Challenges. The Journal of Economic Perspectives, Vol. 37(No. 1), pp. 3-30.
<https://www.jstor.org/stable/27192407>

ногдуулж, зорилтот этгээдийн тодорхой хөрөнгө, санхүүгийн үйлчилгээг хязгаарлах хэлбэрээр хэрэгжүүлж болно.

Desbordes R., Munier F. (2023) судалгаанд хориг арга хэмжээ авахад хүргэж буй дараах гол шалтгаанууд байна гэж үзжээ². Үүнээс хүний эрхийг хамгаалах, ардчиллыг хамгаалах болон зорилтот улс орны баримталж буй бодлогоо өөрчлөхийг шаардах зорилгоор хориг арга хэмжээ ногдуулах нь элбэг байгааг харж болно.


Зураг 1. Хориг арга хэмжээ авах гол шалтгаан



Эх сурвалж: (Institut Jacques Delors, 2024)

Дараах зурагт 2025 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар хамгийн олон хориг арга хэмжээнд орсон 7 улсыг хориг арга хэмжээний тоогоор харуулав. (Зураг 2)

Зураг 2. Хамгийн олон хориг арга хэмжээнд орсон улс орнууд, 2025



Эх сурвалж: Castellum AI, 2025


² Institut Jacques Delors. (2024, September 26). *Understanding international sanctions*. Institut Jacques Delors. Retrieved May 12, 2025, from https://institutdelors.eu/wp-content/uploads/2024/09/Infographie_Santions_Russie_Matelly_EN_A4.pdf

Дээрх зургаас харахад 2022 оноос хойш ОХУ болон Украин улсын хоорондын дайнтай холбоотойгоор ОХУ-ын эсрэг авч хэрэгжүүлсэн хориг арга хэмжээний тоо огцом нэмэгдсэн болохыг харж болно.

2.1 Хориг арга хэмжээний ангилал

Хориг арга хэмжээг төрөл, цар хүрээ, хориг тавьж буй этгээдээр дараах байдлаар ангилан авч үздэг³.

Зураг 3. ОУ-ын хориг арга хэмжээний ангилал



Эх сурвалж: (Schmitt, 2016)

Хориг арга хэмжээ нь дараах үндсэн 4 төрөлтэй байх бөгөөд эдгээрийг дэлгэрүүлэн авч үзвэл:

1. **Эдийн засгийн хориг арга хэмжээг** “гадаад болон үндэсний аюулгүй байдлын бодлогын зорилгоор уламжлалт худалдаа, санхүүгийн харилцааг таслах арга хэмжээ” гэж тодорхойлж болно. Энэ төрлийн хориг арга хэмжээг улс орнууд түгээмэл ашигладаг бөгөөд дотроо худалдааны хориг, санхүүгийн хориг болон бусад эдийн засгийг хязгаарлах хориг арга хэмжээнээс бүрддэг.

- Худалдааны хориг арга хэмжээ
 - Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хориглох
 - Хөрөнгө оруулалтыг хориглох

³ Schmitt, O. (2016). *International Sanctions*. In M. D. Cavelty, & T. Balzacq (Eds.), *Routledge Handbook of Security Studies* (2nd Ed.) (2nd edition ed., pp. 360-370). Routledge.

- Импорт, экспортод хориг тавих
- Бусад
- Санхүүгийн хориг арга хэмжээ
 - Банк хоорондын гүйлгээнд хориг тавих
 - Валютын гүйлгээг хориглох
 - SWIFT сүлжээнээс тусгаарлах
 - Хуулийн этгээд, хувь хүн, төрийн байгууллагын данс царцаах
 - Хөрөнгө царцаах
 - Бусад
- 2. *Соёл/Спортын (ихэвчлэн бэлгэдлийн шинжтэй) хориг арга хэмжээ* нь олон улсын хамтын нийгэмлэг эсвэл тодорхой бүлэг улс орнууд тухайн улсын тодорхой бодлогыг эсэргүүцэж буйгаа илэрхийлэх арга хэрэгсэл болдог. Энэ төрлийн хориг арга хэмжээ нь нэмэлт зардал, хохирол учруулалгүйгээр байр сууриа илэрхийлэхэд чиглэнэ.
- 3. *Дипломат хориг арга хэмжээ* нь тухайн улсын төрийн төлөөлөгчид болон голлох хувь хүмүүс рүү чиглэсэн байдаг. Энэ хүрээнд хориг арга хэмжээнд орсон улсын дипломат төлөөлөгч, улс төрч, эсвэл нөлөө бүхий хүмүүсийн визийг цуцлах, олон улсын байгууллагад оролцох эрхийг нь хасах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.
- 4. *Цэргийн хориг арга хэмжээ* нь цэрэг хүчний хамтын ажиллагаа руу чиглэдэг. Үүнд цэргийн сургалтын хөтөлбөрүүд, зэвсгийн наймаа, хамтарсан сургуулилтыг түр зогсоох, цуцлах зэрэг арга хэмжээ багтана.

Түүнчлэн хориг арга хэмжээ нь цар хүрээний хувьд улс орныг бүхэлд нь хамарсан цогц шинжтэй эсхүл бизнес эрхлэгчид, бүлгүүд, хувь хүнд чиглэсэн зорилтот шинжтэй байж болно.

Хориг тавьж буй этгээдийг шинж чанараар нь дараах байдлаар ангилан авч үзэж болно.

- *Олон талт* буюу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл эсвэл олон улсын засгийн газар хоорондын байгууллагаас (жишээлбэл, Европын Холбоо) тодорхой улс, хуулийн этгээд, хувь хүнд хориг тавьж болно. Тус хориг арга хэмжээг гишүүн улс орнууд нь дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Монгол Улс нь НҮБ-ийн гишүүн орны хувьд терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хориг арга хэмжээний жагсаалтыг заавал дагаж мөрдөх үүрэг хүлээдэг. Мөн Санхүүгийн хориг хэмжээ авах байгууллага ФАТФ-аас улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэхдээ ФАТФ-ын 40 Зөвлөмжийн хүрээнд авч үздэг. Үүний Зөвлөмж 6, 7-д улс орнуудыг “НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл”-өөс гаргасан үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой хориг арга хэмжээг биелүүлэхийг шаарддаг.

Нэг талт буюу нэг улс өөрийн шийдвэрээр нөгөө улс эсвэл улсын иргэн, хуулийн этгээдийн эсрэг хориг тавьж болно. Улс орон бүрд тодорхой улс, хуулийн этгээд, хувь хүнд нэг талын хориг арга хэмжээ хэрэгжүүлэх талаар дотоодын хууль, журам байдаг. Үүний нэг жишээ нь АНУ бөгөөд тус улс нь 1950-иад оноос хойш хориг арга хэмжээ авах бодлогыг гол хэрэгслээ болгон ашиглаж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд зэрэг 25 улсад хориг тавьсан байна.

Хоёрдогч хориг арга хэмжээ энэ нь хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор хоригт орсон этгээдтэй үйл ажиллагаа явуулж хориг арга хэмжээг тойрон гарахад тусалж буй гуравдагч этгээдийн эсрэг чиглэсэн арга хэмжээ юм.

2.2 Хориг арга хэмжээний хэрэгжилт

Хориг арга хэмжээг тогтоож буй этгээдээс шалтгаалан түүний эрх зүйн хүчин чадал, хэрэгжүүлэх эрх зүйн орчин харилцан адилгүй байдаг. Олон талт буюу НҮБ-ын Аюулгүй зөвлөлийн баталсан хориг арга хэмжээг НҮБ-ын гишүүн орон бүр заавал дагаж мөрдөх шаардлагатай байдаг. Харин нэг талт, эсхүл НҮБ-аас өөр олон улсын засгийн газар хоорондын байгууллагын гаргасан хориг арга хэмжээг бусад улс орнууд олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр заавал дагаж мөрдөх үүрэг хүлээдэггүй бөгөөд зарим орнууд экстерриториаль нэг талт хоригийг олон улсын эрх зүйтэй харшилдаг гэж үздэг. Гэсэн хэдий ч, хоёрдогч хориг арга хэмжээний эрсдэлээс шалтгаалан харгалзан үзэх шаардлагатай байдаг.

Олон улсад хориг арга хэмжээний хэрэгжилттэй холбоотойгоор хориг арга хэмжээнээс зайлсхийх (sanction evasion) болон хориг арга хэмжээг тойрон гарах (sanction circumvention) асуудал үүсэж байна. Хориг арга хэмжээнээс зайлсхийх болон хориг арга хэмжээг тойрон гарах гэсэн ойлголтууд хоорондоо холбоотой боловч агуулгын хувьд ялгаатай ойлголтууд юм.

Хориг арга хэмжээнээс зайлсхийх	Хориг арга хэмжээг тойрон гарах
Тодорхойлолт: Хориг арга хэмжээнд хамаарах этгээд, хөрөнгө, санхүүгийн гүйлгээ, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ болон тэдгээрийн хоорондын холбоог санаатайгаар нуун далдлах, худал, төөрөгдүүлсэн мэдээлэл ашиглах, хяналт шалгалтаас зайлсхийх замаар хориг арга хэмжээний хэрэгжилтээс зайлсхийх үйлдэл юм. Жишээ: Хориг арга хэмжээний жагсаалтад орсон этгээдийн нэр, эцсийн өмчлөгчийн мэдээллийг нуун дарагдуулах, төлбөрийн зориулалт болон гүйлгээнд оролцогч талын мэдээллийг өөрчлөх, хуурамч гэрээ, нэхэмжлэх, тээврийн баримт бичиг	Тодорхойлолт: Хориг арга хэмжээний үйлчлэл, зорилго, үр нөлөөг сулруулах, эсхүл хоригт хамаарах үйл ажиллагааг үргэлжлүүлэх зорилгоор гуравдагч улс, хуулийн этгээд, хувь хүн, зуучлагч, төлбөр тооцооны өөр суваг, өмчлөл болон хяналтын шинэ бүтэц, худалдаа болон тээвэрлэлтийн өөр маршрут ашиглах үйлдлийг хэлнэ. Жишээ: Хориг арга хэмжээ тогтоогдохоос өмнө хоригт хамаарах этгээдтэй шууд хийж байсан худалдаа, төлбөр тооцоог хориг арга хэмжээ тогтоосны дараа шинээр байгуулагдсан компани, гуравдагч улсын зуучлагч, өөр санхүүгийн байгууллага, реэкспорт болон дамжин өнгөрөх худалдааны хэлбэрээр үргэлжлүүлэх нь

ашиглах зэрэг нь хориг арга хэмжээнээс зайлсхийхэд ашиглагдах боломжтой. Гүйлгээний хяналт: Нэр тулгах, гүйлгээ болон баримт бичгийн мэдээллийн зөрүү, нуун далдлах шинж, эцсийн өмчлөгч болон холбоо хамаарлыг шалгах	хориг арга хэмжээг тойрон гарах эрсдэлийг илэрхийлж болно. Гүйлгээний хяналт: Гүйлгээний хэв маяг, өмчлөл/хяналт, зуучлагч, гуравдагч улс, худалдааны маршрут болон хориг хэрэгжиж эхэлсний өмнөх/дараах өөрчлөлтийг харьцуулан шинжлэх
---	--

Хориг арга хэмжээнээс зайлсхийх болон тойрон гарах үйл ажиллагаа нь нэг схемд хоёул зэрэг илэрч болно. Тухайлбал, хориг арга хэмжээнд орсон этгээд өөрийн эзэмшлийн компанийг итгэмжлэгдсэн этгээдэд шилжүүлж, гуравдагч улсад шинээр байгуулагдсан компаниар дамжуулан бизнесээ үргэлжлүүлэхийн зэрэгцээ эцсийн өмчлөгч болон барааны эцсийн хэрэглэгчийн мэдээллийг худал мэдүүлсэн тохиолдолд өмчлөл, зуучлагч, гуравдагч улсыг ашигласан хэсэг нь хориг арга хэмжээг тойрон гарах, харин бодит эзэмшил, оролцогч талын мэдээллийг нуун далдалсан хэсэг нь хориг арга хэмжээнээс зайлсхийх шинжийг агуулна.

Иймд мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчаа зөвхөн хориг арга хэмжээний жагсаалтад орсон этгээдтэй нэр таарсан эсэхийг шалгах аас гадна тухайн харилцагч, гүйлгээ, өмчлөл болон худалдааны бүтэц нь хориг арга хэмжээ хэрэгжиж эхэлсний дараа өөрчлөгдсөн эсэх, шинэ зуучлагч, гуравдагч улс, хамаарал бүхий этгээдээр дамжуулан өмнөх үйл ажиллагааг үргэлжлүүлж байгаа эсэхийг эрсдэлд суурилсан байдлаар авч үзэх шаардлагатай.

2.3 Хориг арга хэмжээний ач холбогдол, үр дагавар

Хориг арга хэмжээний үр дүн, нөлөөллийн талаар олон судалгааны бүтээлүүдэд ялгаатай байдлаар дурдсан байдаг. Эдгээрээс нийтлэг байдлаар хориг арга хэмжээний ач холбогдол болон үр дагаврын талаар хэрхэн тодорхойлсныг дор нэгтгэн харуулав.

Хориг арга хэмжээний ач холбогдол

Олон улсын хориг арга хэмжээ нь улс орнуудын эсвэл олон улсын байгууллагуудын зүгээс зөрчлийг хязгаарлах, олон улсын хууль, дүрэм журмыг сахиулах, энх тайван, аюулгүй байдлыг хангах, хүний эрхийг хамгаалах зорилготой гадаад бодлогын хэрэгсэл юм. Эдгээр арга хэмжээ нь тодорхой этгээд, байгууллага, улс орны эдийн засаг, цэрэг, улс төрийн хүчин чадлыг сулруулах замаар үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл бодлогын нь өөрчлөлтөд нөлөө үзүүлэхэд чиглэдэг. Түүнчлэн хориг арга хэмжээ нь олон улсын хамтын нийгэмлэгийн шударга ёсны тогтолцоог хадгалах, эрх нь зөрчигдсөн ард иргэдийн эрх ашгийг хамгаалах, зөрчил гаргасан этгээдэд хууль ёсны хариуцлага хүлээлгэхэд чухал үүрэгтэй байна.

Хориг арга хэмжээний үр дагавар

Нөгөө талаас хориг арга хэмжээ нь зорилтот этгээдээс гадна тухайн улсын энгийн иргэд, эмзэг бүлгийнхний амьжиргаанд сөргөөр нөлөөлөх хандлагатай байдаг. Тэр дундаа нэг улсыг чиглэсэн хориг арга хэмжээ нь хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээ, ажилгүйдэл, ядууралд сөргөөр нөлөөлдөг болохыг судалгааны бүтээлүүдэд

дурдсан байна. Түүнчлэн хориг арга хэмжээ нь улс орны дотоод улс төрийн тогтвортой байдлыг алдагдуулж, хэт туйлшрал, эсэргүүцлийг өдөөдөг төдийгүй бүс нутгийн эдийн засаг, хөрөнгө оруулалт, худалдаанд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлдэг. Хориг нь гадаад харилцаанд хамгийн сүүлийн сонголт байдлаар хэрэглэгддэг билээ.

Орчин үед улс орнууд хориг арга хэмжээний сөрөг үр дагаврыг бууруулахын зэрэгцээ тодорхой этгээд, үйл ажиллагаанд чиглэсэн **зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг** түлхүү хэрэгжүүлж байна. Гэвч хориг арга хэмжээг тойрон гарах үйлдэл нь түүний үр нөлөөг сулруулж, улмаар тавьсан зорилгодоо хүрэхгүй байх эрсдэлийг бий болгодог. Иймд хориг арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, түүнийг тойрон гарах эрсдэлийг бууруулахад мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн **хориг арга хэмжээ болон түүнийг тойрон гарах нийтлэг арга хэлбэр, эрсдэлийн талаар ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх** шаардлагатай байна.

2.4 Хоёрдогч хориг арга хэмжээ

Санхүүгийн хориг арга хэмжээг тойрон гарах үйл ажиллагаа нарийн төвөгтэй болж, нэмэгдэж байгаатай холбоотойгоор улс орнууд хоёрдогч хориг арга хэмжээг ихээхэн ашиглах болсон байна. Хоёрдогч хориг арга хэмжээ нь хориг арга хэмжээнд орсон этгээдийн үйл ажиллагааг хэвийн явагдуулахад туслалцаа үзүүлсэн санхүүгийн байгууллага, хувь хүн, бусад хуулийн этгээдийг хамраад байгаа бөгөөд үүнтэй холбоотой олон улсын кейсийг дор тусгав.

Олон улсын кейс:

Кейс 1. Туркийн Халк Банк нь Иран улсад тавьсан хориг арга хэмжээг зөрчин 20 тэрбум ам.долларын шилжүүлгийг зуучилсан, мөн Турк, АНЭУ, Иран улсуудад үйл ажиллагаа явуулж буй компаниудаар дамжуулан АНУ-ын санхүүгийн системийг ашиглан мөнгө угаасан болох нь тогтоогдсон байна.

Кейс 2. ОФАК нь БНХАУ-ын Хэбэй Шинхай Химийн Групп ХХК (*Hebei Xinhai Chemical Group Co., Ltd.*) болон Хятадын Дуньин боомтод (Dongying Port) үйл ажиллагаа явуулдаг гурван компанийг Иран улсын түүхий нефтийг импортолсон гэх шалтгаанаар хориг арга хэмжээний жагсаалтад оруулсан байна.

Кейс 3. Aiotec GmbH компани нь Австралид байрлах полипропилен боловсруулах үйлдвэрийг Иран улсад худалдах үйл ажиллагааг явуулж, эцсийн өмчлөгчийг Турк улсад байгаа хэмээн худал мэдүүлсэн нь тогтоогдсон тул Ираны арилжаа болон хоригийн зохицуулалтын журам (Iranian Transactions and Sanctions Regulations)-ыг зөрчсөн хэрэгт холбогдсон. Үүний улмаас тус компани нь ОФАК-д 14.5 сая ам.долларын торгууль төлөхөөр болсон байна.

III. САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ ОЛОН УЛСАД

Санхүүгийн хориг арга хэмжээнээс зайлсхийх үйлдлүүд сүүлийн жилүүдэд улам нарийсаж, олон улсын анхаарлын төвд орж байна. Эдийн засгийн хориг арга хэмжээг зөвхөн тухайн бүс нутагт авдаг боловч тухайн хориг арга хэмжээнээс зайлсхийх зорилготой үйл ажиллагаа нь бүс нутаг дамнаж, хүндрэл учруулж байна. Түүнчлэн олон улсад авч буй хориг арга хэмжээ нь дэлхийн улс төр, аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилготой боловч түүнээс зайлсхийх олон хэлбэр бүхий стратеги, арга барилууд нь улам бүр боловсронгуй болж байна.

Хориг арга хэмжээний жагсаалтад орсон этгээдүүдтэй санаатай болон санамсаргүйгээр бизнес, санхүүгийн хэлцэл хийх замаар гуравдагч улс, компани, хувь хүмүүс *хоёрдогч хориг арга хэмжээнд өртөх өндөр эрсдэлтэй* тулгарч байгаа нь хориг арга хэмжээг зөрчихтэй тэмцэх бодлого, хяналтыг сайжруулах шалтгаан болж байна. Ийм нөхцөлд хориг арга хэмжээнээс зайлсхийх болон тойрон гарах оролдлогын хэлбэр, түүнтэй холбоотой эрсдэл, үр дагаврыг нарийвчлан судлах нь бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдалд чухал ач холбогдолтой байна.

Олон улсад санхүүгийн хориг арга хэмжээг гуравдагч улс, зуучлагч болон худалдааны өөр маршрут ашиглах, виртуал хөрөнгийг ашиглах зэрэг байдлаар тойрон гарах түгээмэл арга замыг ашиглаж байна. Дэлгэрэнгүй типологийг 5-р бүлгээс харна уу.

3.1 Хориг арга хэмжээг тойрон гарахад гуравдагч улс, зуучлагч болон худалдааны өөр маршрут ашиглах

Хориг арга хэмжээний цар хүрээ нэмэгдэхийн хэрээр хориг арга хэмжээнд хамаарах улс, этгээдүүд шууд худалдаа, санхүүгийн харилцаагаа үргэлжлүүлэх боломж хязгаарлагддаг. Энэ нөхцөлд гуравдагч улс, зуучлагч хуулийн этгээд, ре-экспорт, дамжин өнгөрөх худалдаа болон төлбөр тооцооны өөр маршрут ашиглах замаар хориг арга хэмжээг тойрон гарах эрсдэл нэмэгддэг.

Хориг арга хэмжээг тойрон гарахад дараах нийтлэг арга хэлбэрийг ашиглаж болно. Үүнд:

- гуравдагч улсад шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг импортлогч, экспортлогч, худалдан авагч эсхүл төлбөр төлөгчөөр ашиглах;
- өмнө нь шууд хийгдэж байсан төлбөр тооцоог өөр улс дахь банк, санхүүгийн байгууллага болон зуучлагч компаниар дамжуулах;
- бараа бүтээгдэхүүнийг эцсийн хүрэх улсад шууд нийлүүлэхийн оронд гуравдагч улсад эхлэн нийлүүлж, улмаар ре-экспортлох;
- тээвэрлэлт, дамжин өнгөрөх маршрут, consignee буюу бараа хүлээн авагчийг өөрчлөх;
- барааны эцсийн хэрэглэгч, эцсийн хүрэх газар болон бодит худалдан авагчийг зуучлагч компаниар халхавчлах;
- хориг арга хэмжээ хэрэгжиж эхэлснээс хойш өмнөх худалдааны хэмжээ, давтамж, барааны төрөлтэй ижил төстэй үйл ажиллагааг шинэ компани эсхүл шинэ улсаар дамжуулан үргэлжлүүлэх.

Гуравдагч улс ашиглаж байгаа нь дангаараа хориг арга хэмжээг тойрон гарахыг нотлох үндэслэл болохгүй. Харин өмнөх гүйлгээ, худалдааны хэв маягтай харьцуулахад төлбөрийн маршрут, эсрэг тал, бараа бүтээгдэхүүний хүрэх газар, худалдан авагч болон өмчлөл, хяналтын бүтэц огцом өөрчлөгдөж, эдгээр өөрчлөлт нь эдийн засгийн үндэслэлгүй буюу хориг арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн хугацаатай давхцаж байвал нэмэлтээр нягтлан шалгах шаардлагатай.

Иймд хориг арга хэмжээг тойрон гарах эрсдэлийг үнэлэхдээ зөвхөн тухайн улсын газар зүйн байршил, улс төрийн харилцаанд үндэслэхгүйгээр тухайн гүйлгээний эдийн засгийн үндэслэл, талуудын хоорондын холбоо, худалдааны түүх, барааны шинж чанар, эцсийн хэрэглэгч, төлбөрийн маршрут болон хориг арга хэмжээ хэрэгжиж эхэлснээс хойших зан төлөвийн өөрчлөлтийг хамтад нь авч үзэх нь зүйтэй.

3.2 Хориг арга хэмжээнээс зайлсхийх, тойрон гарах зорилгоор виртуал хөрөнгийг ашиглах

“Chainalysis” байгууллагаас гаргасан “Крипто гэмт хэргийн тайлан 2025”-д 2020-2024 оны хугацаанд хууль бус хаягаас хүлээн авсан нийт криптовалютын дүнг харуулсан байгааг доор Зураг 5-т харуулав.

Зураг 5. Хууль бус хаягаас хүлээн авсан нийт криптовалютын дүн



Эх сурвалж: (Chainalysis, 2025)

Зургаас харвал 2022 оноос хойш хоригт орсон улс орон, хуулийн этгээдүүд криптовалютаар төлбөр хүлээн авах нь нэмэгдсэн байгаа нь харагдаж байна (ногоон болон бүдэг шар өнгөөр дүрслэгдсэн). Мөн 2024 онд хоригт орсон улс орон, хуулийн этгээдүүд 15.8 тэрбум ам.долларыг хүлээн авсан нь нийт хууль бус крипто гүйлгээний 39%-ийг эзэлж байна.

Хориг арга хэмжээнд хамаарах этгээд нь уламжлалт банк, санхүүгийн системээр дамжуулан хил дамнасан төлбөр тооцоо хийх боломж хязгаарлагдсан тохиолдолд виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, гуравдагч этгээдийн данс болон төлбөрийн өөр сувгийг ашиглан хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах замаар хориг арга хэмжээний хэрэгжилтээс зайлсхийх, тойрон гарах эрсдэлтэй.

Тухайлбал, хориг арга хэмжээнд хамаарах этгээд нь өөрийн нэр дээрх банкны данс болон виртуал хөрөнгийн хаягийг шууд ашиглахын оронд хориг арга хэмжээнд хамаарахгүй хувь хүн, хуулийн этгээд, зуучлагчийн данс болон виртуал хөрөнгийн хаягийг ашиглан мөнгөн хөрөнгийг виртуал хөрөнгөд хөрвүүлэх, хэд хэдэн виртуал хөрөнгийн хаяг, үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан шилжүүлэх, улмаар өөр улсад дахин мөнгөн хөрөнгө болгон хөрвүүлэх байдлаар хөрөнгийн гарал үүсэл, эзэмшигч, эцсийн хүлээн авагч болон гүйлгээний холбоог нуун далдалж болно.

Ийм схемд уламжлалт санхүүгийн болон виртуал хөрөнгийн системийг хослуулан ашиглаж болох бөгөөд дараах байдлаар хөрөнгийн урсгал явагдаж болно:

Хориг арга хэмжээнд хамаарах этгээд

- зуучлагч / хамаарал бүхий этгээд
- виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
- нэг буюу хэд хэдэн виртуал хөрөнгийн хаяг
- гуравдагч улсын үйлчилгээ үзүүлэгч / зуучлагч
- эцсийн хүлээн авагч

Энэ тохиолдолд виртуал хөрөнгө ашигласан нь дангаараа хориг арга хэмжээнээс зайлсхийсэн, тойрон гарсан гэж үзэх үндэслэл болохгүй. Харин виртуал хөрөнгийн гүйлгээ нь хориг арга хэмжээнд хамаарах этгээдтэй шууд болон шууд бус холбоотой эсэх, зуучлагч болон гуравдагч этгээд ашигласан байдал, гүйлгээний эдийн засгийн үндэслэл, хөрөнгийн эх үүсвэр болон эцсийн хүлээн авагчийг бусад мэдээлэлтэй хамтатган үнэлэх шаардлагатай.

IV. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

НҮБ-ын Дүрмийн 41-р зүйлд тусгасны дагуу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс хориг арга хэмжээний жагсаалт гаргадаг бөгөөд Монгол Улс НҮБ-аас гаргасан хориг арга хэмжээг дагаж биелүүлэх үүрэг хүлээдэг. Энэхүү үүргээ хэрхэн хэрэгжүүлэх талаар ФАТФ-ын Зөвлөмж 6, 7-д тусгасан байдаг. Монгол Улс нь эдгээр зөвлөмжийн хүрээнд ихэнхийг биелүүлсэн үнэлгээ авсан бөгөөд хориг арга хэмжээтэй холбоотой асуудлыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон тэдгээрт холбогдон гарсан журмаар зохицуулдаг.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам”-ын дагуу Монгол Улсад байгаа хүн бүр санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Дээрх хууль, журмын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа аливаа хүн, хуулийн этгээд, эсхүл Монгол Улсын гадна байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээд бүр НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан эсхүл Монгол Улсын эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд хөрөнгө бий болгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, гүйлгээ хийхийг хориглосон байдаг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 6¹ дүгээр зүйлд “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх” тухай зохицуулсан байдаг. Үүнд:

- НҮБ-ын АЗ-ийн хориг арга хэмжээний жагсаалтад орсон этгээдэд үйлчилгээ үзүүлэхийг хориглох;
- жагсаалтад орсон этгээдтэй холбоотой данс, хөрөнгийн хөдөлгөөнийг нэн даруй зогсоох;
- холбогдох этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр арга хэмжээ авах;
- энэ талаар Санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдээлэх;
- жагсаалтыг мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд хүргэх;
- хэрэгжилт, тайлагналын журмыг тусгай журмаар зохицуулах

Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн үйл ажиллагааг нарийвчлан заасан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.6-д энэ журмын 2.1-д заасны дагуу эрсдэлийн үнэлгээ хийхдээ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсэг болон 6 дугаар зүйлд заасан өндөр эрсдэлтэй бизнесийн харилцааг хамруулахын зэрэгцээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ гэсэн байна. Уг хүчин зүйлсийн жагсаалтын 2.6.2.2.санхүүгийн хориг арга хэмжээ, хязгаарлалт болон ижил төстэй арга хэмжээнд орсон улс орнууд гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10 дугаар зүйлд хориг арга хэмжээг эрүүгийн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээр тусгасан байдаг бол


Зөрчлийн тухай хуулийн 5.10 дугаар зүйлд хориг арга хэмжээнд орсон этгээдтэй холбогдсон, туслалцаа үзүүлсэн, хөрөнгийг царцаагаагүй, тагнуулын байгууллагад мэдэгдээгүй зэрэг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд тусгасан үүргээ биелүүлээгүй бөгөөд тэр нь гэмт хэргийн шинжгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар шийтгэл хүлээлгэхээр тусгасан байдаг.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.29-д заасны дагуу НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс, эсхүл төрийн холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх талаар МУТСТ тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй, тэрхүү үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан байна.

Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх уг тогтолцооны хүрээнд мэдээлэх үүрэгтэй этгээдүүд хориг арга хэмжээний жагсаалтыг харилцагч, холбогдох этгээдтэй тулган шалгах, жагсаалтад хамаарах этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг нэн даруй зогсоох, холбогдох мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх, бусад хуульд заасан үүргийг хүлээдэг. Харин хориг арга хэмжээг тойрон гарах оролдлогыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажиллагаа нь эрсдэлд суурилсан харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тогтоох, байнгын хяналт хийх болон сэжигтэй гүйлгээг мэдээлэх тогтолцоотой уялдан хэрэгжих юм. Иймд мэдээлэх үүрэгтэй этгээд харилцагчийн эрсдэлийг үнэлэх, харилцагчаа таньж мэдэх, гүйлгээний хяналт хэрэгжүүлэх явцдаа хоригоос зайлсхийх гэх агуулгаас гадна хориг арга хэмжээг тойрон гарах гэх агуулгыг харгалзан үзэж, холбогдох эрсдэлийн шинж тэмдгийг судлах нь зүйтэй.

Санхүүгийн мэдээллийн албанд 2022 оны 7 дугаар сараас хойш хүлээн авсан сэжигтэй гүйлгээний тайлангаас хориг арга хэмжээтэй холбоотой сэжиглэх үндэслэлийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Зураг 6: Хориг арга хэмжээтэй холбоотой сэжиглэх үндэслэл (Сэжигтэй гүйлгээний тайлангаас)



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

V. ТИПОЛОГИ


5.1 Санхүүгийн хориг арга хэмжээнээс зайлсхийх болон хориг арга хэмжээг тойрон гарах олон улсын типологи

Олон улсад санхүүгийн хориг арга хэмжээнээс зайлсхийх, тойрон гарах дараах түгээмэл типологиуд байдаг. Тухайлбал, эцсийн өмчлөгчийг нуух, виртуал хөрөнгө ашиглах, олон улсын санхүүгийн дундын тогтолцоог ашиглах, бараа бүтээгдэхүүний гарал үүслийг өөрчлөх, хуурамч бичиг баримт ашиглах, гуравдагч этгээдийг ашиглах, шинэ нэр, байгууллага үүсгэх гэх мэт.

Типологи 1. Эцсийн өмчлөгчийг нуун далдлах замаар санхүүгийн хориг арга хэмжээг тойрон гарах

ОХУ-ын олигарх нь Кайманы арлуудад бүртгэлтэй нэгэн Хедж сангийн шууд бус хөрөнгө оруулагч бөгөөд нийт хөрөнгийн 40 хувийг эзэмшдэг. Тус хедж сангийн 60 хувийг тус олигархын **түнш** эзэмшдэг бөгөөд тэд хедж сангийн бүх хөрөнгийг өөрсдийн хяналтдаа байлгадаг. Уг сан нь Сингапур, АНУ, Их Британи улсуудын гурван гадаад компанид хөрөнгө оруулалт хийсэн байна.

Зураг 7. Эцсийн өмчлөгчийг нуун далдлах замаар санхүүгийн хориг арга хэмжээнээс зайлсхийх



Эх сурвалж: (ACAMS, 2023)


Түүнчлэн тус олигарх нь Швейцар улсад итгэлцлийн сан байгуулж Кипр улсад төвтэй трастын үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан хөрөнгөө удирддаг. Итгэлцлийн сангийн

ашиг шим хүртэгчээр (beneficiary) хоёр хүүхдээ, ашиг шим хүртэгчийг хамгаалагчаар (protector) эхнэрээ бүртгүүлсэн байна. Итгэлцлийн сангийн хөрөнгө нь АНУ, АНЭУ-д байрлах хоёр тансаг зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгө, АНУ-дахь санхүүгийн байгууллагад байршуулсан их хэмжээний мөнгөн хөрөнгө бүхий банкны данс зэрэг болно. Олигарх нь уг гэр бүлийн итгэлцлийн санг өөрийн хяналтдаа байлгадаг.

Мөн тус олигарх Британийн Виржинийн арлууд, Багам, Бермудын арлуудад бүртгэлтэй гурван холдинг компанийн эцсийн өмчлөгч бөгөөд тус компаниудаар дамжуулан эцсийн өмчлөгчөө нуун далдалж, хувийн онгоц эзэмшсэн байна. Дээрх зурагт харуулсанчлан Британийн Виржинийн аралд бүртгэлтэй компанийн хувьцаа эзэмшигч, удирдлагаар тус олигархыг төлөөлсөн 2 этгээд бүртгэгдсэн байна.

Типологи 2. Хоёрдмол зориулалттай бараа бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгч, зориулалт болон хүргэлтийн байршлыг нуун далдлах замаар хориг арга хэмжээнээс зайлсхийх

Зураг 8. Хоёрдмол зориулалттай бараа бүтээгдэхүүнийг худалдан авах түгээмэл типологи



Эх сурвалж: (ACAMS, 2023)

Хоёрдмол зориулалттай бараа бүтээгдэхүүн: Хориг арга хэмжээний жагсаалтад орсон ОХУ-ын төрийн өндөр албан тушаалтан нь төрийн өмчит “Defense Co” компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг. “Defense Co”-ийн борлуулалтын менежер нь Хонг Конг болон АНЭУ-д хоёр холдинг компани байгуулж, тэдгээрээр дамжуулан Израил улсад бүртгэлтэй “Front Co” компанийг шууд бусаар эзэмшдэг. “Front Co” компани нь АНУ-ын үйлдвэрлэгчээс хоёрдмол зориулалттай (иргэний болон цэргийн зориулалтаар ашиглах боломжтой) бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа барааны эцсийн зориулалт, хэрэглэгч болон хүргэх эцсийн байршлын талаар худал мэдүүлж, бараа бүтээгдэхүүн “Front Co” компанид ирсний дараа түүнийг ОХУ дахь “Defense Co” компани руу илгээдэг.

Тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүн: ОХУ-ын нэгэн жижиглэн худалдааны компани 2022 оноос өмнө Европын Холбооны үйлдвэрлэгчдээс тансаг хэрэглээний бараа шууд худалдан авдаг байв. Харин 2022 оноос хойш тус компани Турк улсад зуучлагч (дундын) компани байгуулжээ. Уг компанийг тус жижиглэн худалдааны компани нь АНЭУ болон Кипр улсад бүртгэлтэй хоёр холдинг компаниар дамжуулан эзэмшдэг байна. Турк дахь зуучлагч (дундын) байгууллага нь Европын Холбооны үйлдвэрлэгчдэд тансаг хэрэглээний барааны захиалга өгөхдөө тус барааг ОХУ руу явуулахгүй байх талаар баталгаа гаргадаг. Гэвч барааг хүлээн авсны дараа, Турк дахь зуучлагч (дундын) этгээд нь анхдагч жижиглэн худалдааны компанид буюу ОХУ руу илгээдэг ба тус жижиглэн худалдааны компанийн одоогийн цор ганц эзэмшигч нь хориг арга хэмжээний жагсаалтад багтсан ОХУ-ын төрийн өндөр албан тушаалтны эхнэр байжээ.

Типологи 3. Виртуал хөрөнгө болон зуучлагчийн сүлжээ ашиглан хориг арга хэмжээг тойрон гарах

АНУ-ын Сангийн яамны Гадаад хөрөнгийн хяналтын алба (OFAC) 2024 оны 12 дугаар сард хоригт орсон ОХУ-ын этгээдүүдийн нэрийн өмнөөс хориг арга хэмжээг тойрон гарахад дэмжлэг үзүүлсэн олон улсын санхүүгийн сүлжээ болох TGR Group-тэй холбоотой хувь хүн, хуулийн этгээдүүдэд хориг арга хэмжээ авсан байна. Уг сүлжээ нь виртуал хөрөнгө болон олон улсын зуучлагчдын сүлжээг ашиглан хөрөнгө шилжүүлэх, хөрөнгийн эх үүсвэр болон эцсийн ашиг хүртэгчтэй холбоотой мэдээллийг бүдгэрүүлэх, улмаар хориг арга хэмжээний хязгаарлалтыг тойрон гарахад ашиглагдаж байжээ.

OFAC-ийн мэдээлснээр тус сүлжээ нь бэлэн мөнгийг виртуал хөрөнгөд хөрвүүлэх, виртуал хөрөнгийг бэлэн мөнгө болгох, хориг арга хэмжээнд хамаарах этгээдүүдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, мөн хөрөнгийн өмчлөл, эх үүсвэрийг нуун далдлахад чиглэсэн үйлчилгээ үзүүлж байсан байна. Сүлжээ нь олон улс дахь компани, хувь хүн болон санхүүгийн зуучлагчдыг ашигласнаар хориг арга хэмжээнд хамаарах этгээд болон хөрөнгийн шилжилтийн хоорондох шууд холбоог тогтооход хүндрэл учруулж байв.

Зураг 9. Виртуал хөрөнгө болон зуучлагчийн сүлжээ ашиглан хориг арга хэмжээг тойрон гарах типологи

Виртуал хөрөнгө болон зуучлагчийн сүлжээ ашиглан хориг арга хэмжээг тойрон гарах схем (TGR Group кейс)



Эх сурвалж:
U.S. Department of the Treasury, Office of Foreign Assets Control (OFAC)

Treasury Exposes Money Laundering Network Using Digital Assets to Evade Sanctions (2024.12.04)
<https://home.treasury.gov/news/press-releases/jy2735>

Товч тайлбар:

- TGR Group нь хоригт орсон ОХУ-ын этгээдүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор олон улсын санхүүгийн сүлжээ байгуулж, бэлэн мөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлж байв.
- Уг сүлжээ нь мөнгө болон виртуал хөрөнгийг хөрвүүлэх үйлчилгээ, олон улсын зуучлагч, халхавч компаниуд, төлбөр тооцооны байгууллагууд болон криптовалютын хаягуудыг ашиглан хориг арга хэмжээг тойрон гарахад дэмжлэг үзүүлсэн.
- 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр OFAC нь TGR Group-тэй холбоотой 5 хувь хүн, 4 хуулийн этгээдэд хориг арга хэмжээг авсан.

VI. ШИНЖ ТЭМДЭГ

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хориг арга хэмжээнд орсон улс орон, хуулийн этгээд, хувь хүн болон тэдгээртэй холбоотой харилцагчтай холбоотой дараах шинж тэмдгийг олж таних, арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх нь энэ төрлийн эрсдэлээс хамгаалах арга юм. Санхүүгийн хориг арга хэмжээнээс зайлсхийх, тойрон гарахтай холбоотой олон төрлийн шинж тэмдэг байж болох бөгөөд нийтлэг шинж тэмдгийг дор ангилан харуулав. Үүнд:

6.1 Бараа бүтээгдэхүүний импорт болон экспорттой холбоотой шинж тэмдэг

Арга хэлбэр	Шинж тэмдэг/red flag/
Ашиг хүртэгч, эзэмшигч болон эцсийн хэрэглэгчийг нуун далдлах зорилгоор тээвэр зуучийн компаниудыг ашиглах	- Тээвэр зуучийн компани нь тухайн барааны эцсийн хэрэглэгчээр бүртгэгдсэн байх - Үйлчлүүлэгч эсвэл худалдан авагч эцсийн хэрэглээний талаарх мэдээлэл өгөхөөс татгалзах - Хүргэлтийн огноо тодорхойгүй, эсвэл хаяг нь онцгой, зайдуу байршилд байх - Хүлээн авагч тал нь тухайн бараатай нийцэхгүй үйл ажиллагаа явуулдаг байх - Гүйлгээний гэрээ, нэхэмжлэх, тээвэрлэлтийн бичиг баримт дээр нэг этгээд/компани байгаа боловч бараа, хөрөнгө бодитоор өөр этгээдэд зориулагдсан байх
Бүрдэл хэсгүүдийг олон нийлүүлэгчээс авч, худалдан авалтыг нуух	- Нэг ижил төрлийн бүтээгдэхүүнийг олон эх сурвалжаас авч, бодит хэрэгцээ, зориулалтыг нуух - Барааны шинж чанар, техник үзүүлэлт нь худалдан авагчийн бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй байх - Бараа нь хүлээн авагч орны техник технологийн хөгжлийн түвшинд тохирохгүй байх. (Жишээ нь, электроник үйлдвэрлэл байхгүй улсад хагас дамжуулагчийн тоног төхөөрөмж илгээх.) - Харилцагч нь угсрах, суурилуулах, засвар үйлчилгээ зэрэг нийтлэг үйлчилгээний саналаас татгалзах - Нийлүүлэлтийн сүлжээг зориудаар олон шаттай болгох
Импорт, экспортын худалдан авалтыг буруу тэмдэглэх (mislabelling)	- Барааны мэдүүлсэн үнэ, тоо хэмжээ, тодорхойлолт нь бодит байдлаас зөрүүтэй байх - Барааны үнийг зориуд хэт өндрөөр эсвэл хэт багаар үнэлэх. - Барааны шинж чанарыг зориудаар буруу мэдээлэх, эсвэл хүрэх газрын талаар хуурамч мэдээлэл оруулах. - Хориг, экспортын хяналтад хамаарах барааг өөр

	ангилалд оруулах, ерөнхий нэршлээр мэдүүлэх • Хоёрдмол зориулалттай барааг ахуйн зориулалттай бараа мэт тайлбарлах. • Хяналттай барааг бусад бараатай хамтатган, тодорхой бус эсхүл ерөнхий нэршлээр тээвэрлэх
Гуравдагч орны дамжин өнгөрөх газруудыг ашиглах	• Тээвэр зуучийн төвүүдээс барааг хүлээн авсан этгээд цааш нь хоригт орсон орон руу дамжуулах.

6.2 Харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой шинж тэмдэг

Арга хэлбэр	Шинж тэмдэг/red flag/
Халхавч компани ашиглах	• Хувь хүмүүс, эцсийн хэрэглэгчийн мэдээллийг нуун далдлах зорилгоор гадаад, дотоодын бүртгэлтэй компанийг халхавч болгон ашиглах • Байгууллага нь хэт төвөгтэй эзэмшлийн бүтэц, зохион байгуулалттай байх • Содон нэртэй, хууль ёсны бизнес мэт боловч цахим орчинд огт мэдээлэл байхгүй байх. • Хориг арга хэмжээг тойрон гарах эрсдэл өндөртэй гэж үнэлэгдсэн улс, бүс нутагтай гүйлгээгээр холбогдох.
Хэт төвөгтэй гүйлгээний бүтцийг ашиглах	• Санхүүгийн урсгалыг гуравдагч орноор дамжуулах замаар эцсийн эзэмшигч болон барааны очих газрыг нуух. • Гүйлгээнд оролцогч талуудын хаяг нь бизнесийн үйл ажиллагаатайгаа тохирохгүй байх.
Итгэл хүлээсэн этгээд, зуучлагчдыг ашиглан нөлөөг хадгалах	• Хуульч, нягтлан бодогч, трастын үйлчилгээ үзүүлэгч, итгэмжлэгдсэн этгээд гэх мэт мэргэжлийн зуучлагч ашиглан хөрөнгийн бодит хяналтыг нуух. • Санхүүгийн хоригийн тухай нарийвчилсан асуултад мэдээлэл өгөхөөс татгалзах, зуучлагчаар дамжуулан харилцдаг байх.
Хөрөнгийн бодит эзэмшлийг өөрчлөх	• Хориг арга хэмжээ хэрэгжихийн өмнө эсхүл дараа компанийн эзэмшлийг бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл хувь эзэмшлийг хэд хэдэн этгээдэд хуваах замаар хориг арга хэмжээний холбогдох өмчлөл, хяналтын шалгуурт хамаарахгүй мэт бүтэц бий болгох • Харилцагчийн санхүүгийн байдал нь эзэмшиж буй хөрөнгөтэй нийцэхгүй байх • Урт хугацааны зээл хэлбэрээр хөрөнгийн хяналтдаа байлгах.

Хуурамч нэр, салбар компани, дамжуулсан эзэмшигч	- Компанийг хувиргасан, орчуулсан нэрээр бүртгүүлэх. - Эзэмшигчийн талаарх мэдээлэл нь оффшор бүсэд бүртгэгдсэн байх.
Хамаарал бүхий хүмүүсийг ашиглах	- Хориг арга хэмжээнд орсон этгээдийн хөрөнгийг хамаатан, хамаарал бүхий этгээдээр дамжуулан шилжүүлэх. - Хувьцаа, хөрөнгөө хямд үнээр гэр бүлдээ шилжүүлж, хориг тавихаас өмнө хөрөнгөө ашиглах. - Хориг арга хэмжээг тойрон гарах эрсдэл өндөртэй гэж үнэлэгдсэн улс, бүс нутгийн санхүүгийн байгууллагыг ашиглах.
Үл хөдлөх хөрөнгөөр хөрөнгө нуун далдлах	- Санхүүгийн эх үүсвэр нь тодорхойгүй хөрөнгөөр өндөр үнэтэй үл хөдлөх хөрөнгө худалдан авах. - Бэлэн мөнгөөр зах зээлийн үнээс зөрүүтэй хэлцэл хийх - Гадаад улсын дансаар төлбөр тооцоо хийх, худалдан авагч нь өөр этгээд байх, мөнгө нь гуравдагч эх сурвалжаас ирэх гэх мэт.
“Тусгай зориулалтын төсөл”, FSS/FSB сертификат	Тусгай зориулалтын төслүүд нь ихэвчлэн цэргийн зориулалттай байж болзошгүй байдаг. Иймд, Энэ төрлийн гэрчилгээтэй компаниудтай холбоотой гүйлгээ байгаа тохиолдолд анхаарч авч үзэх хэрэгтэй.

6.3 Санхүүгийн системтэй холбоотой шинж тэмдэг

Арга хэлбэр	Шинж тэмдэг/red flag/
Санхүүгийн системийг ашиглах нийтлэг арга	Хориг арга хэмжээнээс зайлсхийх зорилгоор хоригт орсон этгээдүүд банк, санхүүгийн системийг олон төрлөөр ашигладаг. Үүнд: - Гүйлгээ, захиалгын хэмжээ огцом өсөх: Бодит хэрэгцээтэй харьцуулахад хэт өндөр дүнтэй эсвэл байнга давтагдсан гүйлгээ хийх - Захиалсан бараа, үйл ажиллагааны чиглэл зөрөх: Худалдан авагчийн бизнесийн чиглэлтэй нийцэхгүй бүтээгдэхүүн худалдан авах - Санхүүгийн байгууллага, компанийн бүртгэгдсэн улс орнууд өөр байх: Компанийн бүртгэл нэг улсад байгаа ч санхүүгийн үйлчилгээ нь хориг арга хэмжээг тойрон гарах эрсдэл өндөртэй гэж үнэлэгдсэн улс, бүс нутагт хийгддэг байх. - Гадаад валютын гэнэтийн гүйлгээ: Ялангуяа өмнө нь идэвхгүй байсан үйлчлүүлэгчид гэнэт өндөр дүнтэй

	валют арилжаа хийх нь сэжиглэх үндэслэл болно.
Хөрөнгө, мөнгөн хөрөнгийг нуун далдлах	Хориг арга хэмжээнээс зугтаах нэг гол арга бол хөрөнгийн бодит урсгалыг олон давхарга ашиглан нуух байдаг. Жишээлбэл, • Хэвийн үйл ажиллагаатай үл нийцэх гүйлгээ байнга давтагдах, ижил харилцагчтай ялгаатай нөхцөл бүхий гэрээ хийх. • Гүйлгээний дүнг босго хэмжээнээс доогуур барих замаар санхүүгийн хяналтаас зайлсхийх. • Гуравдагч этгээдээр дамжуулсан, крипто, бэлэн мөнгө ашигласан төлбөр хийх • Халхавч компани ашиглан нарийн төвөгтэй гүйлгээ хийх. • Зохицуулалт сул орнуудаас гүйлгээ хийх • Баримт бичгийн зөрүүтэй байдал – санхүү, тээвэр, худалдааны баримтууд зөрүүтэй, дутуу байх. • Үнэт эдлэл, уран зураг, үнэт чулуу, алтны худалдааны компаниудын оролцоо их байх – эдгээр нь хөрөнгө нуун далдлахад түлхүү ашиглагддаг. • Их хэмжээний хэмжээний бэлэн мөнгө, эсвэл ховор хэрэглэгддэг валютаар гүйлгээ хийх • Өндөр үнэтэй хөрөнгийг гэнэт худалдах, шилжүүлэх үйлдэл хийх.
Свифт (SWIFT) ашиглах боломжгүй үед виртуал хөрөнгийг ашиглах	• Ойролцоох улс орнуудаас хийгдсэн IP хаягтай гүйлгээ • Хоригт орсон этгээдүүдтэй холбоотой криптовалютын хаягаар хийгдсэн гүйлгээ • Миксинг үйлчилгээ эсвэл рансомвертэй холбоотой крипто хаягтай харилцсан гүйлгээ

6.4 Хориг арга хэмжээ хэрэгжиж эхэлсний дараах үйл ажиллагааны өөрчлөлттэй холбоотой шинж тэмдэг

Арга хэлбэр	Шинж тэмдэг/red flag/
Харилцагч болон төлбөрийн сувгийг өөрчлөх	• Хориг арга хэмжээ хэрэгжиж эхэлсний дараа өмнө нь шууд харилцаж байсан гадаад харилцагчийг өөр хуулийн этгээдээр солих. • Өмнө нь ашиглаж байгаагүй гуравдагч улсын банк, санхүүгийн байгууллагаар төлбөр тооцоо хийх. • Шинээр байгуулагдсан, эсхүл өмнө нь тухайн бизнесийн харилцаанд оролцож байгаагүй зуучлагч компани гүйлгээний сүлжээнд гэнэт орж ирэх. • Хориг арга хэмжээ хэрэгжиж эхэлсний дараа өмнөх

	төлбөр, худалдааны урсгалыг гуравдагч улсын санхүүгийн байгууллага, компаниар дамжуулах.
Бараа бүтээгдэхүүний баримт бичигтэй холбоотой өөрчлөлт	• Гэрээ, нэхэмжлэх, гааль, тээвэр болон бусад худалдааны баримт бичгийн мэдээлэл хоорондоо зөрөх; барааны нэршил, HS код, үнэ, тоо хэмжээ, чиглэл үндэслэлгүйгээр өөрчлөгдөх • Хориг, экспортын хяналтад хамаарах барааг өөр ангилалд оруулах, ерөнхий нэршлээр мэдүүлэх
Гүйлгээний газарзүйн болон дижитал хэв шинжийг өөрчлөх	• Харилцагчийн бодит үйл ажиллагаатай нийцэхгүй улс орноос гүйлгээ хийх. • Өмнө нь ашиглаж байгаагүй улс, санхүүгийн байгууллага, төлбөрийн суваг руу гэнэт шилжих. • Гүйлгээний IP хаяг нь харилцагчийн бүртгэлтэй улс, бодит үйл ажиллагааны байршилтай нийцэхгүй байх. • Богино хугацаанд олон улс орноор дамжсан төлбөрийн болон худалдааны урсгал бий болох.

Монгол Улсын нөхцөлд анхаарах асуудал

Эдгээр шинж тэмдэг дангаараа хориг арга хэмжээг зөрчсөн, зайлсхийсэн эсхүл тойрон гарсан гэж үзэх хангалттай үндэслэл болохгүй. Дээр дурдсан олон улсын типологи, арга хэлбэр, шинж тэмдгүүдийг Монгол Улсын нөхцөлд үүсэж болзошгүй хориг арга хэмжээнээс зайлсхийх, тойрон гарах эрсдэлийг таньж мэдэх, үнэлэх, түүнчлэн Монгол Улсын санхүү, төлбөр тооцоо, гадаад худалдааны тогтолцоог ийм үйл ажиллагаанд ашиглахаас урьдчилан сэргийлэхэд харгалзан үзэх нь зүйтэй.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь тухайн харилцагчийн эрсдэлийн түвшин, бизнесийн үйл ажиллагаа, гүйлгээний эдийн засгийн үндэслэл, өмчлөл болон хяналтын бүтэц, гүйлгээний нөгөө тал болон бусад холбогдох мэдээллийг цогцоор нь үнэлэх шаардлагатай.

Ялангуяа гуравдагч этгээд болон зуучлагч ашиглах, эцсийн өмчлөгч, бодит хяналтыг нуун далдлах, төлбөр болон худалдааны маршрутыг өөрчлөх, барааг дахин экспортлох, виртуал хөрөнгө болон төлбөрийн өөр суваг ашиглах зэрэг арга хэлбэрт анхаарах нь зүйтэй.

VII. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Хориг арга хэмжээг тойрон гарах эрсдэлийг үнэлэхдээ дараах холбоосыг цогцоор нь авч үзэх нь зүйтэй:

Харилцагч → Эцсийн өмчлөгч/бодит хяналт → Гүйлгээний нөгөө тал → Зуучлагч → Төлбөрийн маршрут → Бараа бүтээгдэхүүн → Эцсийн хэрэглэгч → Эцсийн хүрэх газар.

Хориг арга хэмжээг тойрон гарах эрсдэлийг бууруулахын тулд мэдээлэх үүрэгтэй этгээд нь хориг арга хэмжээний жагсаалттай нэр тулгах үйл ажиллагаагаар хязгаарлахгүйгээр харилцагч, эцсийн өмчлөгч, гүйлгээний нөгөө тал, төлбөрийн маршрут, бараа бүтээгдэхүүн, эцсийн хэрэглэгч болон хүрэх газрын хоорондын холбоог эрсдэлд суурилан үнэлэх шаардлагатай. Хориг арга хэмжээний жагсаалт гэдэгт НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орно.

Энэ хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

1. Эцсийн өмчлөгч болон бодит хяналтыг тогтоох

Хориг арга хэмжээний жагсаалтад орсон болон өндөр эрсдэлтэй этгээдэд үйлчилгээ үзүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал, харилцагчийн хувийн хэрэг хөтлөх, хуулийн этгээд болон трастын үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд эцсийн өмчлөгчийн мэдээллийг шаардаж, баталгаажуулах, харилцагч нь бизнесийн зорилго, үйл ажиллагааны онцлогтоо нийцсэн гүйлгээ хийж байгаа талаар нягтлах зэрэг болно. Түүнчлэн хуулийн этгээдийн зөвхөн бүртгэлтэй хувьцаа эзэмшигчийг тогтоохоос гадна тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, хөрөнгө, гэрээ хэлцэл болон санхүүгийн шийдвэрт бодит хяналт хэрэгжүүлж байгаа этгээдийг тогтоох.

2. Харилцагчийг таньж мэдэх, эрсдэлийг үнэлэх

Өндөр эрсдэлтэй улс оронд бүртгэлтэй хуулийн этгээд болон бусад харилцагчдын эрсдэлийг үнэлж, тогтмол хяналт хэрэгжүүлж байх нь урьдчилан сэргийлэх нэг арга зам болно. Энэ хүрээнд хөрөнгийн эх үүсвэр, бизнесийн холбоо хамааралтай этгээд, гүйлгээний шинж чанар зэргийг харгалзан үзвэл зохино.

3. Хориг арга хэмжээнээс өмнөх болон дараах үйл ажиллагааг харьцуулах

Харилцагчийн төлбөрийн эсрэг тал, банк, улс орон, валют, бараа бүтээгдэхүүн, тээврийн маршрут, захирал болон өмчлөгчид гарсан өөрчлөлтийг түүхэн мэдээлэлтэй харьцуулан үнэлэх.

4. Гуравдагч этгээд, зуучлагчийн эдийн засгийн үндэслэлийг тогтоох

Гүйлгээ болон худалдаанд шинээр оролцож буй зуучлагч компани ямар үйлчилгээ үзүүлж байгаа, тухайн компанийн оролцоо бизнесийн бодит хэрэгцээтэй эсэх, зуучлагчийн үйл ажиллагаа, санхүүгийн чадавх болон гүйлгээний хэмжээ хоорондоо нийцэж байгаа эсэхийг шалгах.

5. Төлбөр, худалдааны баримт бичгийг харьцуулах

Гэрээ, нэхэмжлэх, төлбөрийн мэдээлэл, барааны тодорхойлолт, тээврийн баримт, эцсийн хэрэглэгч болон хүрэх газрын мэдээлэл хоорондоо нийцэж байгаа эсэхийг нягтлах.

6. Барааны эцсийн хэрэглэгч, эцсийн хүрэх газрыг тогтоох

Ялангуяа хоёрдмол зориулалттай, өндөр технологийн, үйлдвэрлэлийн болон бусад хориг, хязгаарлалтад өртөх эрсдэлтэй бараа бүтээгдэхүүний хувьд эцсийн хэрэглэгч, хэрэглээний зориулалт, бодит хүрэх газрыг боломжит хэмжээнд тогтоох.

7. Харилцагч болон эсрэг талуудын хоорондын холбоог үнэлэх

Шинэ болон хуучин компаниудын хувьцаа эзэмшигч, захирал, хаяг, төлөөлөгч, холбоо барих мэдээлэл болон бусад нийтлэг шинжийг харьцуулан өмнөх хоригт хамаарах этгээдтэй холбоотой эсэхийг тогтоох.

8. Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан арга хэмжээ хэрэгжүүлэх, сэжигтэй гүйлгээг мэдээлэх

Дээр дурдсан шинж тэмдэг болон бусад эрсдэлийн хүчин зүйлс давхар илэрч, тухайн гүйлгээ, бизнесийн харилцааны эдийн засгийн болон хууль ёсны үндэслэл хангалттай тайлбарлагдахгүй байгаа тохиолдолд ХТМ нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Санхүүгийн мэдээллийн албанд сэжигтэй гүйлгээний мэдээлэл хүргүүлэх.

9. Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг тогтмол сайжруулах, мэдээллээр хангах

Ажилтнуудыг хориг арга хэмжээнээс зайлсхийх, тойрон гарах үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол сургалтад хамруулж, сүүлийн үеийн чиг хандлага, арга хэлбэрийн талаар мэдээллээр хангадаг байх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖ

ACAMS. (2023). *Russia Sanctions Evasion: Key Methods and Techniques – Part 1*. acams.org. <https://www.acams.org/sites/default/files/2023-05/Russia%20Sanctions%20Evasion%20-%20Key%20Methods%20and%20Techniques%20%E2%80%93%20Part%201.pdf>

Braw, E., & Millward, J. A. (2023, June 1). *Russia Dodges Sanctions Thanks to Mongolia's Sketchy Ship Registry*. Foreign Policy. Retrieved April 25, 2025, from <https://foreignpolicy.com/2023/06/01/mongolia-shipping-industry-russia-sanctions/>

BRICS pay. (2021). *The new international payment system*. Retrieved 2025, from https://digitalbankbrics.com/media/NIPS_Presentation_EN.pdf

Castellum.AI. (n.d.). *Consolidated Russia Sanctions Data Dashboard — Castellum.AI*. Castellum.AI. Retrieved May 20, 2025, from <https://www.castellum.ai/russia-sanctions-dashboard>

Chainalysis. (2025). *The 2025 Crypto Crime Report*. 91. <https://www.antiriciclaggiocompliance.it/app/uploads/2025/03/The-2025-Crypto-Crime-Report-Chainalysis.pdf>

European Commission. (2023, September 7). *Sanctions: Commission publishes guidance to help European operators assess sanctions circumvention risks - European Commission*. Retrieved April 19, 2025, from https://finance.ec.europa.eu/news/sanctions-commission-publishes-guidance-help-european-operators-assess-sanctions-circumvention-risks-2023-09-07_en

FIN-FSA. (2024, October 14). *Observations related to sanctions evasion*. Finansivalvonta. Retrieved 2025, from https://www.finanssivalvonta.fi/globalassets/en/publications/supervision-releases/2024/en_havaintoja_pakotteiden_kiertamiseen_liittyen_final.pdf

GOV.UK. (2025, February 25). *Countering Russian sanctions evasion - guidance for exporters*. GOV.UK. Retrieved April 19, 2025, from <https://www.gov.uk/government/publications/countering-russian-sanctions-evasion-and-circumvention/countering-russian-sanctions-evasion-guidance-for-exporters>

Institut Jacques Delors. (2024, September 26). *Understanding international sanctions*. Institut Jacques Delors. Retrieved May 12, 2025, from https://institutdelors.eu/wp-content/uploads/2024/09/Infographie_Santions_Russie_Matelly_EN_A4.pdf

Morgan, T. C., Syropoulos, C., & Yotov, Y. V. (n.d.). Economic Sanctions: Evolution, Consequences, and Challenges. *The Journal of Economic Perspectives*, Vol. 37(No. 1), pp. 3-30. <https://www.jstor.org/stable/27192407>

New Zealand Ministry of Foreign Affairs and Trade. (n.d.). *Sanctions Evasion: Common Red Flags*. Retrieved April 25, 2025, from <https://www.mfat.govt.nz/assets/Countries-and-Regions/Europe/Ukraine/Guidance-note-Sanctions-evasion-red-flags.pdf>

OFAC. (n.d.). OFAC Sanctions List Search. Retrieved May 15, 2025, from <https://sanctionssearch.ofac.treas.gov/>

OFAC. (2022). *Directive 3 under E.O 14024 Prohibitions Related to New Debt and Equity of Certain Russia-related Entities*. Office of Foreign Assets Control. Retrieved May 19, 2025, from <https://ofac.treasury.gov/media/918476/download?inline>

OFAC. (2023, November 2). *Taking Additional Sweeping Measures Against Russia - United States Department of State*. State Department. Retrieved May 19, 2025, from <https://2021-2025.state.gov/taking-additional-sweeping-measures-against-russia/>

OFAC. (2024, June 12). *SANCTIONS ADVISORY Updated Guidance for Foreign Financial Institutions on OFAC Sanctions Authorities Targeting Support to Russia*. Office of Foreign Assets Control. Retrieved April 19, 2025, from <https://ofac.treasury.gov/media/932436/download?inline=>

Schmitt, O. (2016). International Sanctions. *Routledge Handbook of Security Studies (2nd Ed.)*, 360-370. <https://olivier-schmitt.com/wp-content/uploads/2016/07/international-sanctions.pdf>

UN Security Council. (2021, March 4). *S/2021/211 Security Council*. Security Council. Retrieved 2025, from https://www.securitycouncilreport.org/atf/cf/%7B65BFCF9B-6D27-4E9C-8CD3-CF6E4FF96FF9%7D/s_2021_211.pdf

U.S. Department of the Treasury. (2024, March 25). *Treasury Designates Russian Companies Supporting Sanctions Evasion Through Virtual Asset Services and Technology Procurement*. Treasury. Retrieved 2025, from <https://home.treasury.gov/news/press-releases/jy2204>